



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР

Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ


2022 оны 10 дугаар сарын байдлаар

Мөрөн сум

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 10 сарын байдлаар 1908 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 349 тохиолдол буюу 15.5%-иар буурсан байна. Төрөлт Бүрэнтогтох, Галт, Жаргалант, Их-Уул, Түнэл, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган сумдад өсч бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрсөн эхчүүдээс 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хамрагдалтын хувь 69.0% байна.





ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 10 сарын байдлаар нийт 1916 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 348 тохиолдолоор буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 3,6 хувь /69/ нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн байна. Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 96,1 хувь байна. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 2022 оны эхний 10 сард нийт 52423 хүүхэд жинлэж, жинлэсэн хүүхдийн 0.1 хувь нь туранхай, 0,1 хувь нь тураалтай, 0,1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 37.3 хувь нь А амин дэм, 56.6 хувь нь Д амин дэм, 6.6 хувь нь олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн байна.

НЯЛХАСЫН ЭНДЭГДЭЛ

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 10 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 30 тохиолдол бүртгэгдсэн нь 2021 оны мөн үеэс 3 тохиолдлоор буурч, 1000 амьд төрөлтөнд 15.7 ногдож байна. Нялхсын эндэгдлийн 46.7 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд 7.3 байна. Нийт 21 тохиолдол буюу 70.0 хувь нь эмнэлэгт эндсэн бөгөөд 18 нь эрэгтэй хүүхэд байна.

Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:



1-5 НАС ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2022 оны эхний 10 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 6 тохиолдлоор буурсан байна. 1000 амьд төрөлтөнд 2.1 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны эмгэг 1, амьсгалын тогтолцооны эмгэг 1, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл,
бодит тоогоор



НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

2022 оны эхний 10 сарын байдлаар 651 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 6 тохиолдолоор буурсан байна. Нийт нас баралтын 21,5 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 28,6 хувь нь хоног болоогүй нас баралт байна. Осол гэмтлийн нас баралт 110 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 28 тохиолдолоор өссөн, нийт нас баралтын 16,9 хувийг эзэлж, 10000 хүн амд 8,0 ногдож байна. Хорт хавдрын нас баралт 167 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 16 тохиолдлоор өсч, нийт нас баралтын 25,7 хувийг эзэлж, 10000 хүн амд 12,2 ногдож байна.

Нас баралтын мэдээлэл,
2022 оны эхний 10 сарын байдлаар



Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 17.5
2. Гадны шалтгаант өвчлөл- 8.0
3. Амьсгалын тогтолцооны өвчин-2,7
4. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-2.4

Осол гэмтлийн шалтгаант нас баралт, 2022 оны эхний 10 сарын байдлаар




Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 10 сарын байдлаар нийт эдийн шинжилгээ 875, эсийн шинжилгээ 3862 хийгдсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 98 нас баралт буюу 50.0% эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдэж үндсэн оношийн зөрүү 2 бүртгэгдсэн байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 49 тохиолдол байна.


АМБУЛАТОРИ СТАЦИОНАРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 10 сарын байдлаар амбулаторид нийт 396915 үзлэг хийгдсэнээс 28.6 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 55.3 хувийг өвчний учир амбулаторид, 9.3хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 4.5 хувийг гэрийн идэвхитэй үзлэг, 2.3 хувийг гэрийн дуудлагын үзлэг эзэлж байна.

Амбулаторийн үзлэгийн төрөл




Амбулаторийн үзлэг, 2021-2022 оны эхний 10 сарын байдлаар



ЖИРЭМСЭНИЙ ХЯНАЛТ

Шинээр хяналтанд авсан нийт 1926 жирэмсэн эмэгтэйчүүдээс 89.8 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтанд хамрагдсан байна. Цусны шинжилгээнд 93.7 хувь нь хамрагдаж, 1.2 хувь нь цус багатай гарсан байна. Эхний 10 сарын байдлаар жирэмсний хяналтанд шинээр орсон эхчүүдээс трихомониаз, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 93.8 хувийг, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 95.1 хувийг, ХДХВ илрүүлэх шинжилгээнд 94.5 хувийг тус тус хамруулж заг хүйтэн-50, трихомониаз-18, тэмбүү-32 тохиолдлыг тус тус бүртгэн эмчилсэн байна.



ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2022 оны эхний 10 сарын байдлаар халдварт бус өвчлөл 100141 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 36297 тохиолдлоор буурсан байна. 10000 хүн амд 7317.9 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 1441 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1,4 хувийг эзэлж, 10000 хүн амд 105.3 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/



1. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-1687.4
2. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 1661.7
3. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 1256.8
4. Нүд ба түүний дайврын тогтолцооны өвчин-552.3
5. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-592.8


Стационарт нийт 24875 хүн хэвтэж эмчлүүлсэн ба дундаж ор хоног 6.8, орны эргэлт 26.0, орны фонд ашиглалт 177.1, фонд ашиглалтын хувь 64.4 байна.Тосонцэнгэл, Түнэл орны фонд ашиглалт аймгийн дунджаас дээгүүр, бусад газруудад доогуур хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 10 сарын байдлаар нийт 16817 түргэн тусламжийн дуудлага хүлээж авч гүйцэтгэсэнээс 18,2 хувь /3067/ нь алсын дуудлага, 3,3 хувь /551/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 56.1 дуудлага, АНЭ 20,0 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.

ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны эхний 10 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 29551 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 33.8 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 41.9% эрэгтэй, 58.1% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 4074 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон артерийн гипертензи 1066 буюу 26.2% нь онош баталгаажсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 25259 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 48.6 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 41.1% эрэгтэй, 58.9% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 730 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон 43 буюу 5.9% нь онош баталгаажсан байна.





ӨРХИЙН ЭМТ-ИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 62262 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 36.3 хувь
- Өвчний учир үзлэг 35.0 хувь
- Диспансерийн хяналт 19.8 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 8.2 хувь
- Гэрийн дуудлага 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 100141 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 9.8 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.9 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 661 жирэмсэн эмэгтэйдгээс 87.4 хувийг эрт үед нь хяналтанд авч 100 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 128 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 58 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 55, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн нэгдсэн эмнэлэгт 6 тохиолдол бүртгэгдсэн байна.

ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хувийн эмнэлгүүд нийт 26478 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 4.0 хувь
- Диспансерийн хяналт 2.8 хувь
- Өвчний учир үзлэг 93.2 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 7021 хүн хэвтэн эмчлэгдэж, 51790 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.4 орны эргэлт 25.3 ба орны фонд ашиглалт 187.0, орны фонд ашиглалтын хувь 68.0 байна. Нийт 28 халдварт бус өвчний тохиолдол бүртгэгдсэн байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН


Аймгийн хэмжээнд эхний 10 сарын байдлаар 5386 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 393.6 ногдож байна. 2021 оны мөн үед 16757 тохиолдол, 10000 хүн амд 1441.5 ногдож байжээ. 10000 хүн амд ногдох халдварт өвчний гаралт Цагаан-Үүр, Цэцэрлэг, Шинэ-Идэр, Мөрөн суманд аймгийн дунджаас өндөр байна.

Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 17.3 хувь, сүрьеэ 1.1 хувь, амьсгалын замын өвчин 1.0 хувь, цусан халдвар 0.1 хувь, гэдэсний халдварт өвчин 0.7, арьс салтстаар халдварлах халдвар 0.01, Зоонозын болон мал амьтнаас хүнд халдварладаг өвчлөл 0.3 хувь, Ковид-19 халдвар 79.4 хувийг тус тус эзэлж байна.

ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт цочмог халдварт өвчний 5386 тохиолдлоос:


- Гар хөл амны өвчин 3 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэтэй ижил
- Халдварын гаралтай суулгалт 5 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Ёлом 3 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Гахайн хавдар 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Цусан суулга 24 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор
- Ковид-19 4276 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 11913 тохиолдлоор тус тус буурч
- Сальмонеллэз 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Сүрьеэ 61 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 17 тохиолдлоор
- Хоолны хордлого 8 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 7 тохиолдлоор
- Хепатит А 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит В 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит С 3 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Салхинцэцэг 49 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 31 тохиолдлоор
- Хачигт риккетсиоз 16 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 15 тохиолдлоор буурсан тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.



ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ

- 2022 оны эхний 10 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 3668 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс халууралт тууралт 38.2 хувь (63), цэврүүт тууралт 29.1 хувь (48), цусархаг суулгалт 16.4 хувь (27), шарлалттай 5.5 хувь (9), усархаг суулгалт 2.4 (4), хоолны хордлогот халдвар 8.5 хувь (14) тус тус бүртгэгдсэн байна.
- Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/

Халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц тохиолдол, мэдээлсэнээр




ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН


2022 оны эхний 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 22859 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 1670.5 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 8634 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд

2022 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ийн 20659 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 1509.7 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 7774 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 639.7 байжээ.


Томуу томуу төст өвчин, 10 000 хүн амд




Томуу томуу төст өвчин, долоо хоног



Томуу, томуу төст өвчин (насны бүлэг, хувиар)






АЗЦХХ-ын хэвтэлт (насны бүлэг, хувиар), 2022 он



БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний эзлэх хувь 17.3% (933) тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 2.7% (458) тохиолдол бүртгэгдсэнээс:

- Трихомониаз 59 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор буурч
- Тэмбүү 137 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 12 тохиолдлоор
- Гонококк халдвар 737 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 466 тохиолдлоор тус тус өссөн байна.



Хянасан:
Дүгнэлт хийсэн:

Эрүүл мэндийн газрын дарга М.Үүрийнбаяр
Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
П.Баярмаа